

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Ховд Дулааны станц” ТӨХК-ний 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/01/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 70432545

цахим хаяг: narantuuld@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	6
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8-9
3.6 Зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлт	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
3.10 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
4. Аудитын илрүүлэлт.....	11
4.1 Залруулсан алдаа.....	11
4.4 Зөвлөмж	11-12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЦТС	Цахилгаан түгээх сүлжээ
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ДҮТ	Диспетчерийн үндэсний төв
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

“ХОВД ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ЭНХСАЙХАН
ТАНАА

2022.03.09 № 2/40
тантай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тайланг Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тайланг Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ХБОЛДБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,508,532.21	2,532,391.95
1.1.02	Дансны авлага	653,149,479.38	703,761,833.92
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	0.00	27,418,736.38
1.1.06	Бараа материал	770,794,770.71	920,093,089.70
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,427,452,782.30	1,653,806,051.95
1.2.01	Үндсэн хөрөнгө	10,937,055,247.06	10,843,206,437.85
1.2.02	Биет бус хөрөнгө	210,061,999.88	206,105,999.84
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,147,117,246.94	11,049,312,437.69
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,574,570,029.24	12,703,118,489.64
2.1.1.01	Дансны өглөг	1,113,738,097.23	993,747,414.98
2.1.1.03	Татварын өр	166,995,678.58	94,672,453.76
2.1.1.05	Богино хугацаат зээл	40,000,000.00	-
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	36,732,797.74	9,388,261.94
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	4,160,788.92	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,361,627,362.47	1,097,808,130.68
2.1.2.01	Урт хугацаат зээл	125,069,124.52	-
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	125,069,124.52	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,486,696,486.99	1,097,808,130.68
2.3.01	Өмч: - төрийн	13,285,935,498.23	13,285,935,498.23
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,156,971,401.82	1,156,971,401.82
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	202,150,000.00	556,740,663.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-3,557,183,357.80	-3,394,337,204.09
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	162,846,153.71
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-3,557,183,357.80	-3,557,183,357.80
2.3.11	Эздийн өмчийн дүн	11,087,873,542.25	11,605,310,358.96
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,574,570,029.24	12,703,118,489.64

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	2,724,719,808.31	3,584,347,210.23
02	Борлуулалтын өртөг	2,620,197,583.27	2,935,859,500.77
03	Нийт ашиг(алдагдал)	104,522,225.04	648,487,709.46
05	Хүүгийн орлого	409,489.68	-
08	Бусад орлого	166,848,284.28	239,333,741.90
08.1	Орлогын дүн	167,257,773.96	239,333,741.90

09	Борлуулалт, маркетингийн зардал	235,729,403.70	103,597,226.09
10	Ерөнхий ба удирдлагын зардал	433,847,310.33	621,378,071.56
12.1	Зардлын дүн	669,576,714.03	724,975,297.65
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-397,796,715.03	162,846,153.71
19	Орлогын татварын зардал	40,948.97	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-397,837,664.00	162,846,153.71
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-397,837,664.00	162,846,153.71

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2019 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	13,285,935,498.23	1,156,971,401.82	202,150,000	-	11,485,711,206.25
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-397,837,664.00	-397,837,664.00
09	2020 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	13,285,935,498.23	1,156,971,401.82	202,150,000	-	11,087,873,542.25
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	162,846,153.71	162,846,153.71
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	354,590,663	-	354,590,663.00
17	2021 оны 12 сарын 31-р үлдэгдэл	13,285,935,498.23	1,156,971,401.82	556,740,663	-	11,605,310,358.96

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,765,330,310.21	4,119,877,958.09
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,624,605,173.53	4,047,577,206.09
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	494,490.00	3,749,466.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	140,230,646.68	68,551,286.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,393,299,513.40	3,756,429,073.83
1.2.1	Ажиллагчдад төлсөн	809,294,186.69	977,836,340.12
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	278,543,319.05	330,733,924.37
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	462,007,514.45	712,042,588.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	255,770,835.87	526,352,777.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	430,795,760.00	775,547,395.72
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	42,681,121.13	4,656,683.31
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	106,883,550.21	424,695,032.47
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	900,940.00	897,325.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	6,422,286.00	3,667,007.84

1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	372,030,796.81	363,448,884.26
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	194,368,484.00	199,355,900.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	194,368,484.00	199,355,900.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-194,368,484.00	-199,355,900.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	298,870,967.70	165,069,124.52
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	298,870,967.70	165,069,124.52
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-178,870,967.70	-165,069,124.52
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-1,208,654.89	-976,140.26
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,717,187.10	3,508,532.21
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,508,532.21	2,532,391.95

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020 оны Гүйцэтгэл	2021 он		Харьцуулалт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А	Үйлдвэрлэсэн: Дулааны эрчим хүч	50,334.99	54,893	63,506.38	8,613.18	15.7%
	Түгээсэн: Дулааны эрчим хүч	49,327.63	53,850	62,339.825	8,489.82	15.8%
	Нийт орлого :	2,891,977,582.27	2,898,850,000	3,823,680,952	924,830,952.13	31.9%
	Үүнээс: Цэвэр борлуулалт	2,724,719,808.31	2,896,600,000	3,584,347,210	687,747,210.23	23.7%
Б	Үйл ажиллагааны бусад орлого	167,257,773.96	2,250,000	239,333,742	237,083,741.90	10537.1%
	Нийт зардал	3,289,774,297.30	3,686,299,047	3,660,834,798	(25,464,248.98)	-0.7%
	Үүнээс: Удирдлагын зардал	94,326,193.65	105,078,634	103,135,699	(1,942,935.01)	-1.8%
В	Татварын өмнөх ашиг	(397,796,715.03)	(787,449,047)	162,846,154	950,295,201.11	-120.7%
	Цэвэр ашиг / алдагдал /	(397,837,664.02)	(787,449,047)	162,846,154	950,295,201.11	-120.7%
	Төрийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	0.0%
	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	1.14	1.27	0.96	(0.31)	-24.7%
	Нийт авлага	653,149,479	323,230,493	731,180,570	407,950,077	126.2%
	Нийт өглөг	1,486,696,486	954,982,100	1,097,808,130	142,826,030	15.0%
	Богино хугацаат өр төлбөр	1,361,627,362	954,982,100	1,097,808,130	142,826,030	15.0%
	Урт хугацаат өр төлбөр	125,069,124	-	-	-	
	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт	247,764,300	383,970,000	375,794,600	(8,175,400)	-2.1%
	Нийт ажиллагсдын тоо	107	108	107	(1)	-0.9%
	Нийт цалингийн сан	925,131,700.01	1,065,800,590	1,118,553,884	52,753,294.23	4.9%
	Нэг ажилтны дундаж цалин	720,507	822,377	871,148	48,770.89	5.9%

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зардалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2022 оны 03 дугаар сарын 01-нээс 2022 оны 03 дугаар сарын 09-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 30/1 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Ховд Дулааны станц” ТӨХКомпани нь “Байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэд техник технологийг нэвтрүүлэн стандартад нийцсэн дулааны эрчим хүчээр хэрэглэгчдийг найдвартай хангах” гэсэн зорилтыг үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулаан үйлдвэрлэх,
- Дулаан дамжуулах,
- Дулаанаар зохицуулалттай хангах,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 тоот “Корона вируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол,
- Эрчим хүчний зохицуулах хорооны 462 дугаар тогтоол “Ховд дулааны станц” ТӨХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф,
- Эрчих хүчний сайдын 2021 оны 07 дугаар сарын 22-ны А/129 тоот тушаалаар “Халаалтын улирал эхлэх, дуусах огноог тогтоох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Эрчим хүчний яамны хяналт, шинжилгээ, дотоод аудитын газраас 2020-2021 онуудад Засгийн газраас үзүүлж буй хөнгөлөлтөд хамрагдаж

буй айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын тооцоо, 2022 оны 2 дугаар сард 2021 оны үйл ажиллагаанд дотоод аудитын хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Ховд Дулааны станц” ТӨХК-ний 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 4,119.8 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцон 61.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 46.3 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

“Ховд Дулааны станц” ТӨХК-ний 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 12,703.1 сая төгрөгөөр болж 128.5 сая төгрөгөөр буюу 1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал данс байна.

Тайлант оны эхэнд 3.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 2.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй өмнөх оноос 27.8 хувиар буурсан байна

Авлага оны эхэнд 653.1 сая төгрөг байсан бол оны эцэст 731.2 сая төгрөг болж 78.1 сая төгрөгөөр өссөн үүнээс 286.5 сая төгрөгийг Засгийн газрын 211 дүгээр тогтоолын дагуу ДҮТ-өөс авах авлага, 206.0 сая төгрөгийн авлага нь төсөвт байгууллага, 170.1 сая төгрөг нь аж ахуйн нэгж байгууллагын авлага, 27.4 сая төгрөг нь Татварын авлага /НӨАТ-ийн хувь тэнцүүлэн хасах/, 29.9 сая төгрөг нь айл өрхийн дулааны авлага, 11.3 сая төгрөгийн бусад харилцагчдаас авах авлага байна.

Авлагын дансны үлдэгдлийн 13.4 хувь буюу 97.8 сая төгрөгийн авлага нь Мянган Угалзат ОНӨААТҮГ-тай холбоотой үүссэн бөгөөд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн анхан болон давж заалдах шатны шүүхээр тухайн байгууллага төлөхөөр гарсан ч өнөөг хүртэл төлөөгүйгээс авлага нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 920.1 сая төгрөг болж 149.3 сая төгрөгөөр нэмэгдэж тайлант онд 813.0 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч 663.7 сая төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Тайлант оны эхэнд 1486,7 сая төгрөгийн өр төлбөртэй байсан бол оны эцэст 1,097.8 сая төгрөг болж 388.9 төгрөгөөр буурсан оны эхэнд Хас банкинд төлөх 125,1 сая төгрөгийн урт хугацаат зээл байсан бүрэн төлж барагдуулсан. Үүнээс 94.7 сая төгрөг татварт, 449.0 сая төгрөг нь Ховд ЦТС ХХК-д 109.4 сая, МоЭнКо ХХК-д нүүрсний үнэ 167.9 сая төгрөг нүүрс тээврийн хөлсний өглөг, 9.4 сая төгрөгийн урьдчилж орсон орлого, 267.4 сая төгрөгийн бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 11,605.3 сая төгрөг болж 517.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 162.8 сая төгрөгийн ашигтай ажиллаж, эздийн өмчийн бусад хэсэгт аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 354.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Ховд дулааны станц ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,508.53	2,532.39	(976.14)
АВЛАГА	653,149.48	731,180.57	78,031.09
БАРАА МАТЕРИАЛ	770,794.77	920,093.09	149,298.32
Үндсэн хөрөнгө	10,937,055.25	10,843,206.44	(93,848.81)
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	210,062.00	206,106.00	(3,956.00)
Нийт хөрөнгийн дүн	12,574,570.03	12,703,118.49	128,548.46
ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,486,696.49	1,097,808.13	(388,888.36)
БОГИНО ХУГАЦААТ ӨГЛӨГ	1,361,627.36	1,097,808.13	(263,819.23)
УРТ ХУГАЦААТ ӨГЛӨГ	125,069.13		(125,069.13)
Эздийн өмч	11,087,873.54	11,605,310.36	517,436.82
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	12,574,570.03	12,703,118.49	128,548.46

3.6 Зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлт

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3,20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Ховд Дулааны станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 6.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2020 оны 253 дугаар тушаалаар “Ховд дулааны станц” ТӨХК-ийн техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөөг баталсан байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

“Ховд Дулааны станц” ТӨХК-ний 2021 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түшингийн орлогыг 2,698.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 4,157.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Эрчим хүчний яамнаас “Ховд Дулааны станц” ТӨХК-ний төсвийг 2,898.8 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Зорилтот түвшний гүйцэтгэл

Тайлант онд борлуулалтын орлого 2,896.6, үйл ажиллагааны бус орлого 2.3 сая төгрөг нийт 2,898.8 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр айл өрхөөс 72.7, төсөвт байгууллагаас 2,585.0, аж ахуйн нэгж байгууллагаас 86.5, Засгийн газрын тогтоолоор дулаан хөнгөлөлт 1,103.2, аймгийн ОНХС болон ЗДТГ-аас 228.5, нийгмийн даатгалын тэтгэмж 3.7, бусад орлогоор 40.3 сая төгрөг, нийт 4,119.9 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

“Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг төлөвлөгөөнөөс дулааны эрчим хүч үйлдвэрлэлт 8613 гкалл, түгээлт 8489 гкалл илүү буюу 15.7-15.8 хувиар өссөн, нийт орлогыг 924.8 сая төгрөгөөр давуулан биелсэн, нийт зардлыг 25.5 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан зэрэг үзүүлэлттэй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулах шаардлагатай дараах асуудал байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны захиалгаар “Аймгуудын дулааны станцад утаа шүүх уутат фильтр суурилуулах гэрээ”-г байгуулагдаж 750.0 сая төгрөгийн өртөгтэй утаа шүүх уутат фильтр суурилуулсан байна.

Тус хөрөнгө оруулалтын ажилд 2021 оны 7 сард БОАЖЯ болон Үндэсний агаарын бохирдлыг бууруулах хороотой хамтарсан ажлын хэсэг ажилласан боловч уг ажлыг өнөөдрийг хүртэл хүлээлгэн өгөөгүй ТӨБЗГ-аас тогтоол шийдвэр гаргаагүй, үйлдвэрийн газрын ойролцоох айл өрх, иргэд хөдөлмөрчдөөс утаа, тортог их хэмжээтэй гарч байгаа тухай гомдол шүүмжлэл ирүүлсээр байна.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.8.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Эрчим хүчний яам, Хувьцаа эзэмшигчдийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 6, хараат бус 3, ТУЗ-ын нарийн бичиг 1, нийт 10 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж, ТУЗ нь 2021 онд 6 удаа цахим хуралдаж, 20 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

ТУЗ-ын үйл ажиллагааны зардалд 2021 онд нийт 60.2 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 68.5 сая төгрөгийн зардлыг гаргасан нь тайлант оны дундуур ТУЗ-ийн гишүүдийн сард олгох урамшууллын хэмжээг нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах

ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.10 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 172 мэдээллээс 169 хугацаандаа оруулсан 2 мэдээлэл хугацаа болоогүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Эрчим хүчний яамны дотоод аудитаас салбарын харьяа байгууллагуудын 2021 оны “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд 2022 онд хийгдсэн аудитаар 99.8 хувьтай дүгнэгдсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5 зөвлөмж өгөгдөж 80 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар ТӨХК-ийн худалдан авах ажиллагаа, дотоод хяналт, авлага, өглөг, борлуулалт, бараа материалын зарцуулалттай холбоотой асуудлуудыг анхааран үзэх нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 13.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын холбоотой залруулга хийгдээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Зорилтот түвшинд удирдлагын шатахууны зардлыг 4.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Эрчим хүчний сайдын 2021 оны А/29 тоот тушаалаар “Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2021 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг нэгдүгээр хавсралтаар баталсан заалтыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эдийн засгийн үзүүлэлт зорилтот түвшинд зардлыг бодитой төлөвлөх, шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах,

4.4.2 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эрчим хүчний хамт /тариф/-ын хэлэлцээр, ТУЗ-аар батлуулсан сар, жилийн үр дүнгийн урамшуулал олгох журамд заасны дагуу тухайн оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшинд /үйлдвэрлэлийн хэлтсийн ажилчдад олгох үр дүнгийн урамшуулалд зарцуулах зардлыг батлуулаагүй, батлагдаагүй орон тоонд ажил хавсран ажилласны нэмэгдэл олгосон зэрэг зөрчил илэрлээ.

“Ховд Дулааны станц” ТӨХК-ний 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Энэ нь Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамт/тариф/-ын хэлэлцээрийн 3.8-д “сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг тухайн сарын үйлдвэрлэлийн найдвартай, аюулгүй ажиллагаа, үр ашиг, эрчим хүчний хэмнэлт зэрэг шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл үр дүнд үндэслэн тухайн хамт олны /үйлдвэрийн цех хэлтэс, албадын/ албан тушаалын үндсэн болон тарифт цалингийн 50 хүртэл хувиар бодож олгоно”, 3.20-д “сахилгын нэг төрөлд сахилгын шийтгэлийг хэлбэрүүдийг давхардуулж ногдуулахгүй байх зарчмаар сарын болон жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг ногдох хувиар олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Үйлдвэрлэлийн хэлтсийн ажилчдад олгох үр дүнгийн урамшууллын зардлыг төлөвлөж батлуулан олгох.

4.4.3 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох тогтоол журмыг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	“Ховд Дулааны станц” ТӨХК	3	13.4							3	13.4

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

АХЛАХ АУДИТОР:  Д.НАРАНТУУЛ

ТАЙЛАНГ БИЧСЭН

8417143632

ПН 202273 ДХК6454